


3. Дараах үзүүлэлтүүдийн аль нь хөгжингүй орны шинж вэ? /1 оноо/
 А. Шинээр аж үйлдвэржиж буй В. Хүн амын хэт өсөлттэй
 С. Нийгмийн дундаж давхаргын эзлэх хувь их D. Нийгмийн тэгш бус байдал тод
 Е. Түүхий эдийн гол нийлүүлэгч
4. Солонгосын к-поп, к-драм дуу хөгжим, кино урлаг дэлхий даяар түгэн тархжээ. Энэ нь даяаршлын ямар хэлбэрт орох вэ? /1 оноо/
 А. Эдийн засгийн даяаршил В. Соёлын даяаршил С. Ардчиллын даяаршил
 D. Нийгмийн даяаршил Е. Улс төрийн даяаршил
5. Аж үйлдвэрийн салбаруудыг анхдагч, хоёрдогч, гуравдагч, дөрөвдөгч гэсэн хэв шинжүүдэд ангилдаг. Дөрөвдөгч аж үйлдвэрийн хэв шинжид хамаарахыг нь сонгоно уу. /1 оноо/
 А. Хөдөө аж ахуй В. Боловсруулах үйлдвэр С. Судалгаа шинжилгээ
 D. Үйлчилгээний салбарууд Е. Түүхий эд олборлох салбар
6. Дулаан ба чийгийн хувьд улирлын ялгаа байхгүй, жилийн дундаж температур 20°C-аас дээш байдаг бүслүүр аль нь вэ? /1 оноо/
 А. Сэрүүн бүслүүр В. Дулаан бүслүүр С. Халуун бүслүүр
 D. Хүйтэвтэр бүслүүр Е. Экваторын бүслүүр
7. Монгол улс 150 тэрбум гаруй тн нүүрсний нөөцтэй, 300 гаруй орд илэрцтэй Тавантолгойн нүүрсний орд нь эртний төрмөлийн аль галавт үүссэн бэ? /1 оноо/
 А. Юра В. Карбон С. Перм D. Цэрд Е. Триас
8. Янз бүрийн гадаргын ойлгох чадвар өөр өөр байдаг. Дараах өгөгдлүүдээс хамгийн өндөр альбедотойг нь сонгоно уу /1 оноо/
 А. Зузаан үүл В. Элс С. Ой мод D. Хар зам Е. Цөл
9. Тодорхой температуртай агаарт агуулагдаж болох усны уурын дээд хэмжээг юу гэж нэрлэдэг вэ? /1 оноо/
 А. Дутмаг чийг В. Харьцангуй чийг С. Шүүдэр цэг
 D. Үнэмлэхүй чийгийн багтаамж Е. Үнэмлэхүй чийг
10. Голын эх ба адгийн өндрийн зөрүүг юу гэдэг вэ? /1 оноо/
 А. Голын хэвгий В. Голын унал С. Голын хөндлөн зүсэлт
 D. Голын дундаж гүн Е. Голын сүлжээний нягтшил
11. Зурагт 11-ийн тоогоор тэмдэглэсэн урсгалыг нэрлэнэ үү. /1 оноо/



- А. Перугийн урсгал В. Бразилийн урсгал С. Курисиогийн урсгал
 D. Гольфстримийн урсгал Е. Саргассын урсгал



12. Хөрсний доройтол, элэгдэлд нөлөөлөх НИЙГМИЙН хүчин зүйлийг сонгоно уу.



/1 оноо/

- A. Тогтмол салхины нөлөө ихсэх
B. Усалгаатай талбай намагжих
C. Шар усны үерт автах
D. Хөрсний гулсалтад өртөх
E. Эрдсийн хэмжээ буурах

13. Япон улс 127.000.000 хүн амтай, газар нутгийн хэмжээ 380.000 км² бол хүн амын нягтшил хэд байх вэ? /1 оноо/

- A. 1км²-т 534 хүн ноогдоно
B. 1км²-т 134 хүн ноогдоно
C. 1км²-т 234 хүн ноогдоно
D. 1км²-т 434 хүн ноогдоно
E. 1км²-т 334 хүн ноогдоно

14. Зургийг ажиглан растерийн оновчтой дүрслэлийг сонгоно уу. /1 оноо/



15. Цэгийн оронд тохирох үгийг сонгоно уу. Газарзүйн мэдээллийн систем нь компьютерт суурилсан буюу тоон технологи орон зайнийг ашиглан газарзүйн зураг, газарзүйн мэдээллийн загварчлалыг боловсруулдаг технологийн шийдэл юм. /1 оноо/

- A. тандалт B. байршил C. технологи D. өгөгдөл E. зураглал

16. Дараах улсуудыг орших газартай нь зөв харгалзуулна уу. /1 оноо/

Орших газар	Орших улсууд
1. Арал	а. Казакстан
2. Хойг	б. Сауд Араб
3. Эх газар	в. Шинэ Зеланд

- A. 1а, 2в, 3б B. 1б, 2в, 3а C. 1в, 2а, 3б D. 1б, 2а, 3в E. 1в, 2б, 3а

17. Даяаршлын ЭЕРЭГ талыг дурдсан хариултыг сонгоорой. /1 оноо/

- A. Мэдээ, мэдээлэл солилцох B. Ахуй, хэл соёл уусах
C. Улс орнуудын хөгжлийн ялгаа ихсэх D. Түүхий эдийн үнэд сөрөг нөлөөтэй
E. Цөөхөн улс орон улам хүчирхэгжих



18. Зургийн агуулга юуг илэрхийлж байгааг хариултаас сонгоно уу. /1 оноо/



24. Зургийг


ажиглан

биомандлын хамрах хүрээг тодорхойлсон хариултыг сонгоно уу. /1оноо/



- А. Усан мандал хамаарна.
- В. Чулуун ба усан мандал хамаарна.
- С. Агаар мандал хамаарна.
- Д. Чулуун ба агаар мандал хамаарна.
- Е. Дэлхийн бүх мандал хамаарна.


25. 1800 оны эхэн хүртэл дэлхийн хүн амын тоо 1 тэрбумд хүрдэггүй байв. Графикийг ажиглан дараах өгөгдлүүдээс хэдэн оны хооронд хүн амын өсөлт хамгийн их байгааг сонгоно уу /2 оноо/



- А. 1950-2000
- В. 1900-1950
- С. 1850-1900
- Д. 1800-1850
- Е. 1700-1750



26. Хүн амын суваргыг ажиглан хэдэн насны шатлал дахь ямар хүйсийн хүмүүсийн эзлэх хувь их болохыг тодорхойлоорой. /2 оноо/




- A. 25-29 насны, эмэгтэй
B. 25-29 насны, эрэгтэй
C. 35-39 насны, эрэгтэй
D. 30-34 насны, эрэгтэй
E. 35-39 насны, эмэгтэй

27. Цэгийн оронд тохирох үгийг нөхөөрэй. Монгол улсаас Хятад улс руу жилд дунджаар 50 сая орчим тнтээвэрлэдэг. Үүний дийлэнх ньтээврийн төрлийг ашигладаг байна. /2 оноо/

- A. байгалийн хийг, агаарын
B. алтыг, дамжуулах хоолойн
C. газрын тосыг, усан замын
D. нүүрсийг, авто замын
E. зэсийг, цахилгаан


28. Газар хөдлөлтийн хүч, хугацаа давтамжийг сейсмографийн тусламжтайгаар тогтоож болдог. Зургийг ажиглан хамгийн хүчтэй чичирхийлэл нь хэддэх секундэд болсон байгааг тодорхойлно уу. /2 оноо/



- A. 0.3, 5 дахь секундэд
B. 0.2, 15 дахь секундэд
C. 0.2, 5 дахь секундэд
D. 0.1, 20 дахь секундэд
E. 0.3, 10 дахь секундэд



29. Зургийг ажиглан мезосфер /дунд мандал/-ийн давхаргыг зөв тодорхойлсон хариултыг сонгоорой. /2 оноо/



- A. Үүлгүй. Озоны давхарга оршино.
- B. Цаг агаарын бүх үзэгдэл явагддаг
- C. Температур буурч, салхины хурд 150м/сек хүрнэ.
- D. Температур нэмэгдэж 1500°C хүрнэ.
- E. Ионжилт их, устөрөгч илүү зонхилно.


30. 2005 оны 8 сарын Катрина хар салхины үеэр 1836 хүн амь насаа алдан, 108 тэрбум ам/долларын хохирол учирчээ. Хар салхины үргэлжилсэн өдрүүд болон даралтыг зургаас ажиглан салхины хүч хамгийн их байсан өдрүүдийг сонгоно уу /2 оноо/



- A. 29-30-ны өдрүүд
- B. 24-25-ны өдрүүд
- C. 25-26-ны өдрүүд
- D. 30-31-ны өдрүүд
- E. 26-27-ны өдрүүд



31. Өвөрхангай аймгаас Хятад руу явбал хамгийн ойрын, улирлын чанартай боомт аль нь вэ? /2 оноо/



А. Булган-Такашикен
D. Ханги-Мандал

В. Шивээхүрэн-Сэхэ
Е. Ханх-Монд


С. Цагааннуур-Ташанта

32. Google earth программын зурагт 3-ийн тоогоор тэмдэглэсэн командыг идэвхжүүлээд цаг агаарын ямар элементийг харж болох вэ? /2 оноо/



А. Температур
В. Салхи
С. Хур тунадас
D. Даралт
Е. Үүлшилт

33. Доорх зургийг ашиглан Дэлхий ба Ангараг гаригуудын хоорондын зайг одон орны нэгжээр /о.о.н/ илэрхийлээрэй./1 о.о.н = Нар дэлхий хоёрын хоорондох зай/ /2 оноо/



А. 0.82 о.о.н

В. 0.62 о.о.н

С. 0.72 о.о.н

D. 0.52 о.о.н

Е. 0.92 о.о.н



34. Жилийн хоногийн тоо нь 4 жилд нэг удаа 366 хоног болох үеийг юу гэж нэрлэдэг вэ?

/2 оноо/

А. Өндөр жил В. Илүү сар С. Сарны фаз D. Аргын тоолол Е. Билгийн тоолол

35. Зургийг ажиглан 4 ба 7-ийн тоогоор тэмдэглэгдсэн хаант засаглалтай Ази тивийн улсыг сонгоно уу. /2 оноо/



А. Брунэй, Испани

В. Сауд Араб, Непал

С. Тайланд, Япон

D. Испани, АНЭУ

Е. Ватикан, Норвег

36. Хүн амын ихэнх нь испани хэлтэй, католик шашинтай, хөлбөмбөг тоглож, салса, румба, бүжиглэдэг. Энэ бүс нутаг соёлын газарзүйн тархалтын ямар мужид хамаарах вэ? /2 оноо/

А. Словян ба оросын

В. Зүүн Ази

С. Араб исламын

D. Латин америкийн

Е. Зүүн өмнөд азийн

37. Дараах хотуудаас ЕВРОП тивийн тэргүүлэх зэрэглэлийн альфа хотыг сонгоорой. /2 оноо/

А. Лондон

В. Нью-Йорк

С. Токио

D. Лос-Анжелес

Е. Хонконг

38. Малчин А-ынх 10 үхэр, 5 адуу, 30 ямаа, 45 хонь нийт 90 толгой малтай ба бэлчээрийн даацын хуваарилалт хийхийн тулд бүх сүргийг хонин толгойд шилжүүлэн тооцоолно уу. /1 үхэр=6 хонь, 1 адуу=6 хонь, 1 ямаа=0.9 хонь, 1 хонь=1 хонь/ /2 оноо/

А. 192 хонин толгой

В. 132 хонин толгой

С. 162 хонин толгой


D. 102 хонин толгой

Е. 182 хонин толгой

Бодолт:



39. Дараах графикийг ажиглан интернэтээр мэдээлэл авах хэрэгцээ хамгийн сайн хангагдсан орнуудыг сонгоно уу (Worldwide Statista, 2020) /2 оноо/




- А. Беларус, Латви
В. Узбекистан, Киргизстан
С. Вьетнам, Тайланд
D. Өмнөд Солонгос, Хятад
E. Энэтхэг, Пакистан

40. Жуулчид Хөвсгөл нуур орчмын аялалд гарахаар болжээ. Рекреацийн ямар нөөцөд тулгуурласан аялал болох вэ? /2 оноо/


- А. Шашны сүм хийд, эртний барилга байгууламж
В. Түүхэн хөшөө дурсгал, хиргисүүр, гэрэлт хөшөө
С. Цэнгэг уст нуур, цаатангуудын аж амьдрал
D. Хүний гараар бүтээгдсэн сүм хийд, музей
E. Говийн манхан, рашаан сувиллын газар

41. Тухайн бүсийн онцлогийг зөв тодорхойлсныг нь сонгоно уу. /2 оноо/



- А. Баруун өмнөд Ази - Газрын тосны олборлолт
В. Баруун Европ-Аялал жуулчлал, машин үйлдвэрлэл
С. Зүүн өмнөд Ази-Тээвэр, шинэ аж үйлдвэржилт
D. Зүүн Ази-Технологи, электроник
E. Төв Америк -Хөдөө аж ахуй, газар тариалан

42. Графикийг ажиглаарай. 3-р сард салхины хурд өмнөх оны мөн сараас хэдэн м/сек-ээр нэмэгдсэн байна вэ? /2 оноо/



- A. 2.0 м/сек
- B. 1.0 м/сек
- C. 1.5 м/сек
- D. 0.5 м/сек
- E. 2.5 м/сек


43. Өмнөд Америкийн эх газрын гадаргын байдлыг зөв тодорхойлсон хариултыг сонгоорой. /2 оноо/



- A. Зүүн хойд талаараа уулархаг, гадаргын ус хомс
- B. Баруун талаараа тэгш өндөрлөг, гадаргын ус бага
- C. Зүүн талаараа цөлөрхөг нуурын тархалт их
- D. Баруун талаараа тэгш өндөрлөг
- E. Баруун тал нь уулархаг, зүүн талаараа гадаргын ус их



44. Тасалгааны температур $+20^{\circ}\text{C}$ байв. Үнэмлэхүй чийгийн хэмжээ $14\text{гр}/\text{м}^3$ бол харьцангуй чийгийн хэмжээ хэд байгааг тооцоолно уу? /агаарын температур $+20^{\circ}\text{C}$ байх үед чийгийн багтаамж $17.32\text{ гр}/\text{м}^3$ байна/ **/2 оноо/**
 A. 30.3% B. 19.7% C. 18.3% D. 80.8% E. 66.9%
45. Туркменистан улс дотоодын усны хэрэглээнийхээ 98%-ийг импортоор авдаг. Үүнд нөлөөлсөн БАЙГАЛИЙН хүчин зүйлийг сонгоорой. **/2 оноо/**
 A. Хөвөнгийн тариалалтад ус их хэрэглэнэ B. Хүн амын усны хэрэглээ өндөр
 C. Газар нутгийн дийлэх цөл тархсан D. Дотоодын мөргөлдөөн зөрчил их
 E. Усны зохисгүй хэрэглээтэй
46. Дэд бүтцийн салбарт хөрсний үзүүлэх үүрэг нь юу вэ? **/2 оноо/**
 A. Организмуудын амьдрах орчин B. Нүүрстөрөгч шингээгч
 C. Барилга байгууламж, зам гүүр D. Уур амьсгалыг тэнцвэржүүлдэггүй
 E. Түүх соёлын өв тээгч
47. Google earth-ийн зургийг ажиглан 24-р сургууль Улсын их дэлгүүрээс аль зүгт байгааг тодорхойлоорой. **/2 оноо/**



- A. Баруун урд B. Зүүн хойд C. Баруун хойд D. Зүүн E. Хойд
48. Тус улс нь 2.000.000 хүн амтай, хүн амын ердийн өсөлт нь 2% бол хэдээр нэмэгдсэнийг тооцоолоорой. **/2 оноо/**

- A. 20000
 B. 4000
 C. 40000
 D. 2000
 E. 10000

Бодолт:



49. Сидней хотын агаарын температур $+82^{\circ}\text{F}$, Сингапур хотын агаарын температур $+30^{\circ}\text{C}$ байв. Хоёр хотын агаарын температурын зөрүүг цельсийн хуваариар хэд болохыг тооцоолоорой. /2 оноо/ $(^{\circ}\text{F}-32)/9*5=^{\circ}\text{C}$ /
- A. 22.3°C B. 5.2°C C. 8.5°C D. 2.3°C E. 12.5°C

50. Хүснэгтэн мэдээллийг ашиглан Монгол улсын хөдөө аж ахуйн усны хэрэглээг дэлхийн дундажтай харьцуулан шалтгааныг тодорхойлж тооцоолол хийнэ үү. /2 оноо/

№	Салбар	Дэлхийн дундаж /%/	Монгол улсын дундаж /%/
1	Хөдөө аж ахуй	67	28
2	Хүн амын унд, ахуй	9	16
3	Эрчим хүч	7	25
4	Үйлдвэрлэл	11	8
5	Уул уурхай	2	22
6	Бусад	4	1
Нийт		100	100


- A. Ус түгээх шугам сүлжээний засвар үйлчилгээ муу, 39%-иар их
 B. Хотод амьдрах иргэдийн тоо дэлхийн дунджаас их, 20%-иар их
 C. Орон сууцанд амьдрах иргэдийн тоо их, дунджаас 20%-иар бага
 D. Гэр хороололд амьдрах иргэдийн тоо их, дунджаас 3%-иар их
 E. Хөдөө аж ахуй нь эрчимжиж байгаа, дунджаас 39%-иар бага



Хоёрдугаар хэсэг. НӨХӨХ ДААЛГАВАР

Санамж: Даалгавруудын хариултыг бөглөхдөө хариултын хуудасны 2-р хэсгийг бөглөх заавартай сайтар танилцаарай. Зургийг бодит хэмжээгээр өгөөгүй гэдгийг санаарай.

2.1 Зургийг ажиглан дэлхийн хөдөлгөөний даалгавруудыг гүйцэтгээрэй. /6 оноо/



- I. Дэлхий 3-ын тоогоор тэмдэглэгдсэн байршилд байх үед хойд хагаст улирал болон нарнаас алслагдсан зай ямар байхыг тодорхойлно уу */a/ /2 оноо/*

1. Зун, 152 сая км 2. Намар 150 сая км 3. Хавар 150 сая км
4. Жилийн түрш 150 сая км 5. Өвөл 147 сая км

- II. 4-ийн тоогоор тэмдэглэгдсэн байрлал буюу 9 сарын 21 ХӨ38⁰-д тусах нарны өндрийг тооцоолно үү /bc/ /2 оноо/ $H=90-\varphi$

[illegible]

- ### III. Өгүүлбэрийг нөхөөрэй.


Дэлхийн.....эргэх хөдөлгөөний үр дүнд.....хэмнэл
үүсдэг. /d/ /2 оноо/

1. сарыг, хоногийн
4. тэнхлэгээ, жилийн



2.2 Монгол улсын 2023-2024 оны нислэгийн мэдээллийг ашиглан даалгавруудыг гүйцэтгээрэй. /6 оноо/

I. Улаанбаатараас хамгийн олон хүн зорчсон альфа зэрэглэлийн хот аль нь вэ? **/a/**
/2 оноо/



1.Сөүл


2.Бээжин

3.Токио

4.Истанбул

5.Фукуюк

II. Олон улсын нислэгийн тоон графикийг ашиглан зорчигч өмнөх оноос хэдэн хувиар өссөнийг тооцоолоорой **/bc.d/** **/2 оноо/**


[illegible]

III. Автобус 120 км-ын зайтай хоёр хотын хооронд 28 хүн тээвэрлэсэн бол зорчигч эргэлтийг олоорой. /efgh/ /2 оноо/

[illegible]

2.3 Гадаргыг өөрчилдөг эндоген ба экзоген хүчин зүйлстэй холбогдох даалгавруудыг гүйцэтгээрэй /6 оноо/

I. Зургийг ажиглан Африкийн хавтанд хамаарагдах газар нутгийг нь сонгоно уу /a/ /1 оноо/



1. Атлантын далай, Япон арал
2. Атлантын далай, Мадагаскар арал
3. Атлантын далай, Гренланд арал
4. Энэтхэгийн далай, Тасман арал
5. Карибын тэнгис, Панамын суваг

II. Эндоген ба экзоген үйл явцуудыг зөв харгалзуулна уу. /5 оноо/ [b][c][d][e][f]

b	Газар хөдлөлтийн хүчийг хэмжих нэгж	1	Физик өгөршил
c	Гадарга нурах, бутрах, ус салхинд элэгдэх	2	Давхраат галт уул
d	Тайван ба дэлбэрэлтийн үе ээлжлэн явагддаг	3	Рихтерийн магнитууд
e	Амьтан ургамал элдэв бактерийн үйл явцад чулуулаг задарч бутрах өөрчлөгдөх	4	Синклинал
f	Гадаргын атирааны хотгор хэлбэр	5	Органик өгөршил

2.4 Хүснэгтэн мэдээллийг ашиглан дараах даалгавруудыг гүйцэтгээрэй. /6 оноо/

№	Далайн үзүүлэлтүүд	А. Номхон далай	Б. Атлантын далай	В. Хойд мөсөн далай	Г. Энэтхэгийн далай	Д. Өмнөд далай
1	Талбай /сая.км2/	165.2	92.4	14.0	73.5	15.9
2	Дундаж гүн /м/	4280	3646	1038	3741	4500
3	Температур /°C/	28.3	21.5	-1.2	25.2	2.5
4	Давсжилт /‰/	34.1	33.2	32.1	34.5	34.2

I. Газарзүйн зураг дээр ижил гүнтэй цэгүүдийг холбон зурсан шугамыг юу гэж нэрлэдэг вэ? /a/ /1 оноо/

1. Изогипс
2. Изобар
3. Изотерм
4. Изобат
5. Изотахи

II. Номхон далай ба Энэтхэгийн далайн температурын дундажийг тооцоолоорой. /bc.d/ /2 оноо/

III. Далайн талбайнуудын тоон утгыг ихээс бага руу нь эрэмбэлээрэй. /e/ /3 оноо/

1. Б-А-Г-Д-В
2. А-Б-Г-Д-В
3. Д-Б-Г-А-В
4. Г-Б-А-Д-В
5. В-Б-Г-Д-А

